

ТӨРИЙН ЦЭРГИЙН БОЛОН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН АХЛАГЧИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН ТОГТОЛЦОО, ЗАРИМ ОРНЫ ТҮРШЛАГА

Б.Жавхлан

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны суралцагч, дэд хурандаа

Товч агуулга: Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын мэргэжлийн, байнгын бүрэлдэхүүний 70 гаруй хувийг эзэлж байгаа ахлагч нарын мэргэжил, ур чадвар, боловсрол, нийгмийн байдал нь аливаа аюултай тэмцэх үндэсний чадамжийн чухал үзүүлэлт болдог. Иймээс ахлагч нарын боловсрол мэргэжлийн асуудлыг судалж цаашид ахлагчийн албаны мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоог шинэчлэх загвар боломжийг тодорхойлон санал зөвлөмжийг дэвшүүлэх.

Түлхүүр үгс: Ахлагч нарын боловсрол, мэргэжил, сургалт

Оршил: Цэргийн алба бол Үндсэн хуульд заасан ёсоор насанд хүрэгчдийн гүйцэтгэх үүрэг цэргийн хугацаат алба төдийгүй төрийн албаны онцлог төрөл байна. Монгол Улсын “Цэргийн албаны тухай” хуульд зааснаар цэргийн алба, түүний ангилал, төрлийг тодорхойлсон байдаг. Тухайлбал: Цэргийн алба нь цэргийн жинхэнэ алба, цэргийн бэлтгэл албанаас бүрдэнэ. Цэргийн жинхэнэ алба нь хугацаат болон цэргийн гэрээт алба, ахлагчийн алба, офицерын албанаас бүрдэнэ¹.

Нэг. Ахлагч бэлтгэж ирсэн түүхэн уламжлал.

Ахлагч гэж хэн бэ ?

“Ахлагч” нь нэгд, төрийн цэргийн байгууллага болон хууль сахиулах байгууллагад цэргийн жинхэнэ албыг сайн дураараа ахлагчийн албан тушаалд гэрээгээр хаагч; хоёрт, ахлагчийн албан тушаалд ажиллаж буй цэргийн албан хаагчид олгодог цол; гуравт, цэргийн хэргийн

мэдлэг, чадвар, дадлагыг тухайн шатны сургалтаар эзэмшсэн, цэрэгт бүртгэлтэй мэргэжлээр цэргийн байгууллагад ахлагчийн албан тушаалд цэргийн жинхэнэ алба хаах тодорхой шалгуур, шаардлага хангасан цэргийн алба хаагчийг хэлнэ.

Анх ахлагч цолыг БНМАУ-ын Ардын сайд нарын зөвлөлийн 1942 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 51 дүгээр тогтоолд “Монгол ардын хувьсгалт цэргийн ба Дотоод явдлын яамны харьяа хязгаарын цэргийн жинхэнэ жагсаалын дарга нарт шинээр алдар цол олгох тухай” асуудлыг тодорхойлж бага түрүүч, түрүүч, ахлагч гэсэн цолыг олгохоор баталсан нь түүхийн шаргал хуудаснаа тэмдэглэн үлджээ.

БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн 1944 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн XXII хурлаас “МАХЦ-ийн алба хаагчдын алдар цолыг шинэчлэх тухай” тогтоол гаргаж, МАХЦ-ийн бие бүрэлдэхүүнийг байлдагч, бага дарга, офицер, генерал

гэж нэрлэхээр тогтоож бага дарга нарт бага түрүүч, түрүүч, ахлах түрүүч, ахлагчийн цолыг олгохоор баталсан байна.

1991 онд ахлагч цолыг улирсан цэргийн алба хаагчдад дангаар нь хэрэглүүлж эхлэн дэд ахлагч, ахлагч, ахлах ахлагч гэсэн гурван цолны шатлалтай болгож, алба хаасан жил, ажлын дүнгээр цол шагнадаг болжээ.

Монгол Улсын зэвсэгт хүчинд 2003 онд ахлагчийн цол дэд ахлагч, ахлагч, ахлах ахлагч, сургагч ахлагч, тэргүүн ахлагч гэсэн 5 зэрэглэлд шилжсэн байна.

“Ахлагчийн алба” гэж Монгол Улсын иргэн цэрэгт бүртгэлтэй мэргэжлээр цэргийн байгууллагад ахлагчийн албан тушаалд цэргийн жинхэнэ албыг хаахыг хэлнэ. Монгол Улсын “Цэргийн албаны тухай” хуулийн 10 дугаар зүйлд ахлагчийн албаны тухай тодорхой заасан байдаг.Тухайлбал:

1. Цэргийн зохих шатны сургууль, дамжаанд суралцаж, цэргийн мэргэжил эзэмшсэн 30 хүртэлх насны иргэнийг ахлагчийн албанд элсүүлж болно.

2. Ахлагчийн албан тушаал нь даргалах, гүйцэтгэх гэсэн ангилалтай байна.

3. Ахлагчийн алба хаагч нь боловсрол, мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн зохих шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

4. Энэ зүйлийн 10.3-т заасан шалгуур үзүүлэлтийг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага батална.

5. Иргэн ахлагчийн албыг 47 нас хүртэл хаана.

6. Алба хаах дээд хязгаарт хүрсэн цэргийн мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар, дадлагатай ахлагчийн цэргийн жинхэнэ алба хаах хугацааг томилсон

эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно гэжээ.

Монгол Улсад анх удаа ЦИС-ын бүрэлдэхүүнд мэргэжлийн ахлагч бэлтгэх сургууль байгуулагдаж 1993 оны 9 дүгээр сарын 1-нд 3 офицер, 2 ахлагч, 83 сурагчтайгаар шинэ хичээлийн жилийн нээлтээ хийж эхэлсэн байдаг.

Ахлагч бэлтгэх сургалт нь нэгдүгээрт, 3 сарын хугацаатай цэргийн ерөнхий бэлтгэлийн сургалт; хоёрдугаарт, 5-6 сарын хугацаатай мэргэжил олгох сургалт, гуравдугаарт, төгсөгчдийг 5 жил ажилласны дараа дахин сургаж хос мэргэжил эзэмшүүлэх сургалт гэсэн 3 үе шаттай явагдахаар төлөвлөсөн байна.

Батлан хамгаалахын сайдын 1998 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн тушаалаар “ЦИС-ийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд тус сургуульд 29 мэргэжлээр мянгаад сонсогч суралцагч, 15 мэргэжлээр дээд боловсролтой офицерыг, харин Ахлагч бэлтгэх төв, Цэргийн хөгжмийн сургуульд 13 мэргэжлээр ахлагч нарыг бэлтгэн Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн анги салбарыг хүний нөөцөөр хангаж байсан байна.

Ахлагч бэлтгэх төв нь Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Улсын иргэний хамгаалалтын газар зэрэг хүчний байгууллагуудын захиалгаар мэргэжилтэй хүний нөөцийг бэлтгэж эхэлсэн байна.

1993 онд ЦИС-ын бүрэлдэхүүнд Ахлагч бэлтгэх төв

2001 онд БХИС-ын Ахлагчийн сургууль

2003 онд БХИС-ын Ахлагчийн коллеж

2005 онд БХИС-ын Ахлагчийн сургууль

2020 онд Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв нэртэйгээр үйл ажиллагаагаа одоог хүртэл явуулж байна.

Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн сургалтын талаар:

Дотоод хэргийн их сургуулийн харьяа Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн тухай Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2012 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн А/37 дугаар тушаалаар баталсан ДХИС-ийн бүтцийн өөрчлөлтөөр Мэргэжлийн боловсролын тухай хуульд нийцүүлэн Ахлагчийн сургууль болгон ЦЕГ, ХХЕГ, ШШГЕГ, ОБЕГ-ын захиалгат сургалтуудыг явуулах анхны суурь тавигдсан байна.

Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Б/472 дугаар тушаалаар баталсан бүтэц орон тоогоор Цагдаа, Хил, Шүүхийн шийдвэр, Онцгой, Тактик, тусгай бэлтгэл, Цэргийн албаны гэсэн 6 тэнхимтэйгээр үйл ажиллагааг явуулж байна.

Тус төв нь Мэргэжлийн (богино хугацаа)-ны сургалтыг захиалагч агентлагийн оролцоотой мэргэжлийн зөвлөлөөр (Цагдаа мэргэжлийн “Цагдаа”, Хилийн мэргэжлийн “Хилчин”, Шүүхийн мэргэжлийн “Харуул хамгаалалтын ажилтан”, Онцгой байдлын мэргэжлийн “Аврагч”) хэлэлцэгдэн батлагдсан сургалтын хөтөлбөрөөр 1-4 сарын хугацаатай сургалтыг зохион байгуулж төгсөгч нарт энгэрийн тэмдэг, чадамжийн гэрчилгээ, гэрчилгээ олгож байна.

Цагдаагийн албаны тэнхим нь: Цагдаагийн ерөнхий газар, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захиалгаар “Цагдаагийн байгууллагын

үйл ажиллагааны эрх зүйн үндэс”, “Нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагааны тактик”, “Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа” зэрэг 21 төрлийн хичээлээр сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг.

Хилийн албаны тэнхим нь: Хил хамгаалах ерөнхий газрын захиалгаар “Харуулын дарга”, “Шалган нэвтрүүлэх албаны шалгагч хилчин” ахлагч, “Хилийн цэргийн офицер”, “Хилчин” ахлагч бэлтгэх сургалтад “Хил хамгаалалтын эрх зүй”, “Хилийн манаа”, “Харуулын алба”, “Хил хамгаалалтын тактик”, “Мөр судлал” зэрэг 24 төрлийн хичээлээр сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тэнхим нь: ШШГЕГ-ын захиалгаар “Харуул хамгаалалтын албаны ажилтан” ахлагч бэлтгэх сургалтад “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа”, “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаа” зэрэг 17 төрлийн хичээлээр сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг.

Онцгой байдлын албаны тэнхим нь: ОБЕГ-ын захиалгаар “Аврагч, гал сөнөөгч”, “Аврах гал унтраах автомашины жолооч”, “Холбооны бага мэргэжилтэн” ахлагч бэлтгэх сургалтад “Онцгой байдлын албаны үйл ажиллагааны эрх зүйн үндэс”, “Онцгой байдлын албаны үйл ажиллагааны дүрэм журам”, “Аврагчийн сэтгэл зүй” зэрэг 19 төрлийн хичээлээр сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг.

Тактикийн тэнхим нь дээр дурдсан хөтөлбөрүүдэд сургалт явуулахаас гадна Улаанбаатар төмөр

зам, Иргэний нисэхийн ерөнхий газрын захиалгат мэргэшүүлэх сургалт, аж ахуй нэгж байгууллагын захиалгат “Тэрээт албаны харуул” бэлтгэх сургалтын 1 сарын хугацаатай зохион байгуулж байна.

Сургалтын төгсгөлд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сургалт, үнэлгээ, судалгааны институттэй хамтран “Ур чадварын шалгалт” (чадамжийн үнэлгээ)-г зохион байгуулж чадамжийн гэрчилгээ олгон ажиллаж байна.

Хоёр: Ахлагчийн албаны хөгжлийн олон улсын чиг хандлага, зарим орнуудад ахлагч бэлтгэж буй туршлага.

Орчин үед гадаадын Зэвсэгт хүчнүүдэд мэргэжлийн ахлагч нарын гүйцэтгэх үүрэг, оролцоо нэмэгдэж байна. Мэргэжлийн ахлагч хэмээх ойлголтуудад хөгжиж буй орнуудын хувьд өөрсдийн Зэвсэгт хүчний салбарт (хуурай замын, тэнгисийн, агаарын, хилийн цэргийн гэх мэтээр) дотроо гүйцэтгэх үүрэг онцлогоос нь хамаарч хуваадаг бөгөөд хөрш улсууд болох ОХУ, БНХАУ-аас гадна АНУ, ХБНГ улсуудын мэргэжлийн ахлагч нарыг бэлтгэж буй тогтолцооны талаар судалж үзлээ.

ОХУ-ын ахлагчийн алба, сургалт бэлтгэлийн онцлог:

ОХУ-ын Зэвсэгт хүчин орчин цагийн техникийн хувьсал, хөгжлийг дагаад хугацаат цэргийн алба хаагчид жилийн хугацаанд бүрэн дүүрэн мэргэжил эзэмшихэд хангалтгүй байна хэмээн үзээд дунд шатны техник хэрэгслийн мэргэшсэн ахлагч нарыг бэлтгэхэд анхаарч эхэлсэн.

Иймд Оросын армийн ахлагч бэлтгэх тогтолцоог сэргээж ахлагчийн сургуулийн үйл ажиллагааг мэргэшсэн, тусгай мэргэжлийн алба хаагчдыг шаардлагатай мэргэжлүүдийнх нь

дагуу дунд болон удирдах шатны хэмжээнд бэлтгэх шаардлага тулгарсан. Уг шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор цэргийн тойргуудын материаллаг баазуудыг түшиглэсэн сургалтын дивизүүдийг байгуулан тухайн тойргийн гүйцэтгэх үүрэгт чиглэсэн цэргийн бага мэргэжилтнүүдийг бэлтгэж ирсэн байна.

2009 оны 9 дүгээр сараас ОХУ-ын Зэвсэгт хүчний хэмжээнд ахлагч нарыг бэлтгэх сургуулиудыг үе шаттайгаар хаах шийдвэр гаргаж тухайн үед ажиллаж байсан ахлагчийн бүрэлдэхүүнийг мэргэжлийн бага дарга нар болон гэрээт алба хаагчид болгох санал батлагдсан. Энэ нь ОХУ-ын армийн хэмжээнд ажиллаж байсан 142 мянган хүний ажил амьдрал хөндөгдөж эхэлсэн бөгөөд зарим нь ажлаасаа гарч саналаараа халагдах, сольж, сэлгэн томилж дийлэнх бүрэлдэхүүн нь бага даргаар үлдсэн.

2010 оны 12 дугаар сараас ахлагчийн албанд хүн бэлтгээгүй, ахлагч болон ахлах ахлагч цол дахин хэрэглэхээ больсон. Харин алба хаах хугацаа нь дуусаагүй алба хаагчид хуучин цолоо хадгалан албаа үргэлжлүүлэн хаасан.

Харин энэ үед дотоодын цэрэг, хилийн цэрэг, аюулгүй байдлын алба, улсын хамгаалалтын алба, онцгой байдлын алба зэрэг батлан хамгаалах салбараас шууд хараат бус зарим нэг салбарууд нь энэ өөрчлөлтийн хажуугаар өнгөрч ахлагчийн алба нь хэвийн үйл ажиллагаагаа явуулж байв. 2013 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс ОХУ-ын Батлан хамгаалахын сайд С.К.Шойгу өргөтгөсөн бүрэлдэхүүнээр хуралдсаны эцэст ахлагч бэлтгэх сургуулиудын үйл ажиллагааг хэвийн болгож ахлагчийн албыг эргүүлэн ажиллуулах шийдвэр гаргажээ.

2015 он хүртэл ахлагчийн албанд цэргийн алба хаасан болон хааж байгаа цэргийн алба хаагч аль эсвэл гэрээт цэрэг ахлагчийн албанд элсдэг байв.

2015 оноос эхлэн нэгэн боломж бий болсон нь ерөнхий боловсролын сургуулиа төгсөөд цэргийн албыг түргэвчилсэн байдлаар хааж ахлагчийн сургуульд элсэн суралцах нөхцөлийг бүрдүүлж өгсөн байна. Бүрдүүлэх шаардлагатай үндсэн бичиг баримтууд нь эрүүл мэндийн үзлэгийн хуудас, сэтгэл зүйн хувьд эрүүл гэдгийг батлах хуудсыг чухал шаардлагатай гэж үзжээ.

Элсэгчдийг сонгон шалгаруулалтад хамруулах гол шалгуур нь өөрийн өргөдлийг үндэслэж шийдвэрлэх ба алба хааж байгаа хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдын хувьд өргөдлийг нь ангийн захирагчид уламжлан шийдвэрлүүлэхдээ алба хаах хугацааныхаа талаас дээш хугацааг хаасан цэргийн алба хаагчдыг хамруулдаг байна. Харин албаа хааж буй гэрээт цэргийн хувьд алба хаасан хугацааны шаардлагагүйгээр давуу эрхтэйгээр ахлагчийн албанд элсдэг байна. Гэрээт цэргийн алба хаагчид гэрээ дуусах болоогүй байсан ч өргөдлөө өгч шийдвэрлүүлэн, сурах мэргэжлийнхээ дагуу очих ангиа тодорхой болмогц гэрээт цэргийн алба хаах гэрээгээ цуцлах боломжтой болдог байна.

Цэргийн алба хаагаагүй иргэд өөрсдийн өргөдлийг тухайн газар орныхоо цэргийн штабын даргаар уламжлуулан шийдвэрлүүлэх боломжтой болжээ. Ахлагчийн сургуульд элсэгчдийн насны хязгаар 35 хүртэл бөгөөд хүсэлт гаргагчийг ангийн захирагч бүрэн шийдвэрлэхээр зааж хэрвээ зөвшөөрсөн тохиолдолд

эрүүл мэндийн үзлэгт хамрагдах болон зарим нэг тусгай шалгалт өгдөг байна.

Ахлагчийн сургуульд суралцах хугацаа нь тухайн сонсогчийн сонгосон мэргэжлээс шалтгаалж өөр өөр байна. Хугацааны хувьд хугацаат цэргийн алба хаасан бол 5-10 сар, хугацаат цэргийн алба хаагаагүй бол 2 жил 10 сар хүртэл сунгагдаж болдог байна. Хичээл сургалтын төгсгөлд шалгалтаа амжилттай өгч тэнцсэн бол анги салбарууд руу нь мэргэжлийнх нь дагуу хуваарилж 5-аас доошгүй жил алба хаах гэрээ байгуулдаг байна.

Хятадын ардын чөлөөлөх армийн ахлагчийн албаны онцлог:

ХАЧА-ийн ахлагчийн цол бол ахлагч гэдгийг илэрхийлэх, ахлагчийн зэрэглэлийг ялгах цол тэмдэг бөгөөд нам, төрөөс цэргийн алба хаагчдад өгч буй байр суурь, хүндэтгэл юм.

Ахлагчийн цолыг ахлагч болон хугацаат цэргийн гэж 2 хуваадаг. Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн шийдвэрээр ХАЧА-ийн ахлагчийн цолны зэрэглэлийн тогтоолыг баталж 3 дугаар сарын 31-ний өдрөөс даган мөрдөж байна. Үүнээс өмнө 2009 оноос хойш мөрдөгдөж байсан ахлагчийн цолны зэрэглэл хүчин төгөлдөр үйлчилж байжээ.

Дээрх ахлагчийн цолны зэрэглэлээс харахад ахлах ахлагч цолыг дотор нь 1 дүгээр зэргийн ахлах ахлагч, 2 дугаар зэргийн ахлах ахлагч гэж 2 хувааж, 4 дүгээр зэргийн удирдах ахлагч цолыг хүчингүй болгосон байна. ХАЧА-ийн удирдах ахлагч цолны зэрэглэлийг манай улсын Зэвсэгт хүчинд хэрэглэж буй Тэргүүн ахлагч цолтой дүйцүүлж үзэж болохоор байна.

ХАЧА-ийн ахлагчийн цолны тогтолцоонд өөрчлөлт оруулсныг хүснэгтээр харуулав

Зэрэглэл	Алба хаасан жил	Цол	Цол хоорондын хугацаа
Байлдаг	1 жил	Байлдагч	9 сар орчим
	2 жил	Ахлах байлдагч	1 жил
Бага шатны ахлагч	3-8 жил	Дэд ахлагч	3 жил
		Ахлагч	4 жил
Дунд шатны ахлагч	9-16 жил	II зэргийн ахлах ахлагч	4 жил
		I зэргийн ахлах ахлагч	4 жил
Ахлах шатны ахлагч	17-30 жил	III зэргийн ахлах ахлагч	4 жил
		II зэргийн ахлах ахлагч	4 жил
		I зэргийн ахлах ахлагч	6 жил

ХАЧА-ийн ахлагчийн бүрэлдэхүүнд хоёр төрлийн арга замаар элсэн орох боломжтой. Тухайлбал, хугацаат цэргийн алба хаагчдаас улираах хэлбэрээр болон энгийн иргэдийн дундаас сонгож тухайн анги байгууллагад шаардлагатай мэргэжлээр сургаж авдаг. Энгийн иргэдээс элсүүлэхэд тавигдах шаардлага нь 20-оос доош насны бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой, бие бялдар, эрүүл мэндийн шаардлага хангасан байх ба ажлын ярилцлагад орж тэнцсэн байх шаардлагууд байна. Ажлын байранд очиход хамгийн багадаа 6 сарын цэргийн сургалт, бэлтгэлийг дүүргэсэн байх ёстой. Мөн цэргийн албаны хэрэгцээ шаардлагаар хэрэгцээтэй мэргэжлээр цэргийн бус байгууллагад ажиллаж байсан иргэдийг ахлагчийн албанд элсүүлэх боломж бас байдаг байна.

ХАЧА-ийн ахлагчийн сургуулийн хөтөлбөр нь ямар төрлийн мэргэжлээр сурч байгаагаас хамааран 2-3 жилийн хугацаатай байдаг бөгөөд үүнийг дүүргэсний дараа дунд боловсролын диплом олгодог.

Сонсогчид цол тэмдэг бүхий цэргийн дүрэмт хувцас өмсөж хагас цэрэгжсэн удирдлагатай, дотуур байранд байрлаж суралцдаг байна. Төгссөн сонсогчдыг цэргийн анги байгууллагаас илгээсэн хүсэлтийн дагуу хуваарилдаг.

ХАЧА-ийн дийлэнх хугацаат цэргийн алба хаагчид орчин үеийн зэвсэгт хүчний шаардлагыг хангахгүй, мэдлэг, боловсрол, сургалт бэлтгэлийн түвшин муу байсан тул дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд 1990-ээд оны сүүлээр ахлагчийн корпусыг байгуулсан байна. Үүнээс хойш өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд ахлагчийн хүний нөөцөө бүрдүүлэх зорилгоор олон арга хэмжээ хэрэгжүүлсэн.

Тухайлбал, шаардлагатай мэргэжлээр коллежийн төгсөгч, оюутнуудтай гэрээ байгуулан ахлагчаар элсүүлдэг байсан. Олон төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн хэдий ч тодорхой үр дүнд хүрээгүй. Орчин үеийн зэвсэг техникийг ашиглахад нарийн техникийн өндөр мэргэжилтэй хүмүүс шаардагдах болсон тул “Ахлагчийн зорилтод сургалт”

хөтөлбөрийг ХАЧА-ийн удирдлага санаачлан хэрэгжүүлж байна.

АНУ-ын ахлагч бэлтгэх сургалт:

АНУ-д ахлагчаар элсэхэд тавигдах хамгийн гол шаардлага бол бие бялдрын тэсвэр хатуужилтай байх, гэмт хэрэгт холбогдоогүй байх, олон шивээс хийлгээгүй байхаас гадна ёс зүй, харилцаа, биеэ авч явах байдал талаасаа хамгийн үлгэр жишээ, өө сэвгүй байхыг шаарддаг байна.

Мэргэжлийн ахлагч нарыг бүрдүүлэхэд чиглэсэн хүний нөөцийн цэгцтэй бодлого нь цэргийн байгуулалтад хамгийн чухал байр суурийг эзэлдэг. Мэргэжлийн ахлагч нарын нэр хүнд, тэдгээрийн хувийн бэлтгэл, шаардлага, мэдлэг дадлагаа

ашиглах чадвараас цэргийн алба хаагч нэг бүрийн төдийгүй бүхэл бүтэн нэгтгэл, анги салбарын байлдааны бэлтгэл сургуулилт хамаардаг гэж тунхагладаг.

АНУ-ын армид ахлагч нар салаа салбараас эхлээд удирдлагын дээд штабт, тухайлбал Тэргүүн ахлагч (sergeant Major) цолтон нь ахлах офицерууд, генералуудтай мөр зэрэгцэн штабт ажилладаг. Зэвсэгт хүчний анги салбар бүрд Тэргүүн ахлагч (sergeant Major) үүрэг гүйцэтгэдэг бөгөөд бүх ахлагч нарын шууд захирах дарга нь юм.

АНУ-ын ХЗЦ-ийн ахлагч нарын хувьд 90 гаруй хувь нь коллеж төгссөн байдаг

бөгөөд байлдагчийн хувьд мэргэжлийн ахлагч болохын тулд армид 3-5 жил алба

хаасан байх ёстой. Байлдагч нь энэ хугацаанд цэргийн болон бие бялдрын бэлтгэлийн оноо цуглуулдаг бөгөөд уг үзүүлэлтийг үндэслэн тэднийг Зэвсэгт хүчний

төрөл мэргэжлийн цэргийн ахлагч нарыг бэлтгэх сургуулиудад хуваарилдаг.

Мэргэжлийн ахлагч нарыг бэлтгэх анхан шатны сургалтын хугацаа дунджаар 9 долоо хоног үргэлжилдэг бөгөөд сургалтыг төгссөн ЦАХ-дад анхан шатны ахлагч цолыг олгодог.

Цаашид эдгээр ахлагч нарыг 16 сургалтын төв, институтэд 5 түвшнээр үргэлжлүүлэн бэлтгэж, сургадаг байна. Бэлтгэлийн эхний шатанд ахлагч нарын удирдах ур чадвар, манлайлах чадварыг хөгжүүлэхэд онцгой анхаардаг байна. Харин бэлтгэлийн 2 болон 3 дугаар үе шатанд ахлагч нар цэргийн тодорхой мэргэжлийн (явган цэргийн, танкны, инженерийн, ар талын гэх мэт) бэлтгэлд суралцдаг байна.

АНУ-ын Зэвсэгт хүчний ахлагч нар алба хааж буй анги салбарынхаа зэвсэглэлд байгаа бүх төрлийн зэвсгийг заавал эзэмшсэн байх ёстой байдаг байна.

АНУ-ын Ахлагчийн сургалт бэлтгэл

Бэлтгэлийн түвшин	Үргэлжлэх хугацаа	Хамрагдах бүрэлдэхүүн
1 дүгээр түвшин (Primary Leadership Development Course),(Warrior Leader Course)	30 хоног	Армид 3-5 жил алба хаасны дараа ахлагч болоод удаагүй байгаа ЦАХ-чид
1 дүгээр түвшин (Advanced Leader Course)	8 долоо хоног	Тасгийн дарга нартай дүйцэх түвшний ахлагч нар
3 дугаар түвшин (Advanced Non-Commissioned Officers Course)	8 долоо хоног	Салааны түвшний ахлагч нар
2 дугаар түвшин (First sergeant Course)	5 долоо хоног	Нэгдүгээр зэрэглэлийн ахлагч нар болон мастер ахлагч нар
3 дугаар түвшин (The U.S.Army Sergeant Major Course)	10 сар	Тэргүүн ахлагч

Ахлагч нарыг бэлтгэх бүх шатны дамжаанууд албан тушаал ахихад зайлшгүй шаардлагатай сургалтын хэлбэрүүд бөгөөд цэргийн албаны 20 жилийн туршид эдгээр курсийг шат дараалан дүүргэсэн байна. Зохих курсийг төгссөний дараа цэргийн ээлжит цол буюу ахлагч, штабын ахлагч, нэгдүгээр зэрэглэлийн ахлагч, мастер ахлагч болон тэргүүн ахлагч цолыг олгодог. Тухайлбал, нэгдүгээр зэрэглэлийн ахлагч гэдэг нь зөвхөн ахлагч цолтойгоор 15-аас доошгүй жил алба хаасан, ахлагч нарыг бэлтгэх бүх шатны дамжаа, тусгай бэлтгэлд хамрагдсан удирдлагын ахлагч юм.

Мөн мэргэжлийн ахлагчийн эгнээнээс офицерын албанд шилжин орох нөхцөлийг бүрдүүлсэн байдаг. Тухайлбал, Тухайн ЦАХ АНУ-ын иргэн, коллежийн боловсролтой, цэргийн албанд 18 насандаа элсэн орсон бол 30 нас хүрэхээсээ өмнө Офицерын дамжаа (Officer candidate school)-д орохоор өргөдөл, бичиг баримтаа бүрдүүлэн сонгон шалгаруулалтад хамрагдаж болдог.

12 долоо хоногийн хугацаатай үргэлжлэх энэхүү офицерын дамжаанд АНУ-ын 1 мэргэжлийн ахлагч тутмын нэг нь хамрагдах боломж олгосон байдаг.

АНУ-ын ахлагчийн сургалтууд шаталсан, тасралтгүй, хэлбэрээр явагдах тогтолцоотой ба цол албан тушаал ахихын тулд заавал дараагийн шатны сургалтуудад хамрагддаг байна.

Ахлагчийн сургалт бүрийн дараа болон шалгалт авсны дараа суралцагчдад ажиглагдсан дутагдалтай талуудыг харилцан ярилцаж, гаргасан алдаа дутагдлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг зааж өгдөг.

ХБНГУ-ын Зэвсэгт хүчин (Bundeswehr) ахлагч бэлтгэх сургалт:

Бүгд Найрамдах Герман улсын ахлагчийн цол нь дараах 7 зэрэгтэй байдаг. Үүнд

- 1.Unteroffizeir- бага дарга
2. Stabsunteroffizier- штабын бага дарга
3. Feldwebel- дэд ахлагч
- 4.Oberfeldwebel- ахлагч
- 5.Hauptfeldwebel- ахлах ахлагч

6.Stabsfeldwebel- сургагч ахлагч

7.Oberstabsfeldwebel- тэргүүн ахлагч

ХБНГУ-ын ахлагчийн албан тушаалын 2 бие даасан төрөл байдаг

-Портепеегтэй ахлагч (мөрдөс дээрээ сумтай)

-Портепеегүй ахлагч. Үүрэг даалгавраараа өөр зэрэглэлд ажилладаг энэ 2 ахлагчийн цолны төрөл нь дараах шатлалтай.

Портепеегүй ахлагчийн цол: Ихэнхдээ тасгийн дарга болон туслах албан тушаалд ажилладаг, цэргийн албанд ороод удаагүй 2-5 жил ажиллаж буй ахлагч нар байна.

Unteroffizeir- Портепеегүй дэд ахлагч

Stabsunteroffizier- Штамын портепеегүй ахлагч

Портепеегтэй (мөрдөс дээрээ сумтай) ахлагчийн цол:

Feldwebel- дэд ахлагч

Oberfeldwebel- ахлагч

Hauptfeldwebel- ахлах ахлагч

Stabsfeldwebel- сургагч ахлагч

Oberstabsfeldwebel- тэргүүн ахлагч.

Портепеегтэй ахлагч нар нь ихэнхдээ тухайн салбартаа мэргэшсэн, гол төлөв тасаг, салааны захирагч, салааны орлогч дарга эсвэл штабт бичиг хэрэг, төлөвлөлтийн нэгжид өдөр тутмын уйл ажиллагааг хариуцан ажилладаг.

ХБНГУ-ын ахлагчийн сургуулийн үндсэн үүрэг нь мэргэшсэн, ёс суртахууны өндөр соёлтой, чадварлаг ахлагч нарыг сургаж бэлтгэн, анги салбаруудыг хүний нөөцөөр хангах явдал юм. Тус сургууль нь Штаб болон А, В, С гэсэн үндсэн сургалтын хэсгээс бүрдэх бөгөөд сургалт бэлтгэлийг үе шаттайгаар зохион байгуулахдаа сургалтын хэсгүүдээр дамжуулах хэлбэрийг ашиглан

явуулдаг. Delitzsch хотод тус сургуулийн штаб, А болон С сургалтын хэсгүүд, Monster хотод сургалтын В хэсэг тус тус байрладаг.

А хэсгийн сургалт: А хэсэгт сонсогч нар гадаад хэлний сургалтад хамрагдах бөгөөд тус сургалтаар гадаад хэлний мэдлэгийг тодорхой түвшинд эзэмших, дэлхийн аль ч оронд үүрэг гүйцэтгэх боломж олгоход чиглэгдэнэ.

В хэсгийн сургалт: Сургалтын төлөвлөгөөний дагуу сонсогч нар нь бусад ахлагчийн сургуулийн адил цэргийн мэргэжлийн анхан шатны бэлтгэлд хамрагдах бөгөөд тус сургалт нь сургалтын В хэсэг дээр зохион байгуулагдаж явагддаг.

С хэсгийн сургалт: Төрөл мэргэжлийн сургалтууд нь С хэсэгт зохион байгуулагдах бөгөөд тухайн хэсэгт суралцагч өөр өөрийн үндсэн мэргэжлээр суралцдаг. Германы армийн бие бүрэлдэхүүний 60 орчим хувийг ахлагч нар бүрдүүлдэг тул ахлагч нарынхаа сургалт бэлтгэл, нийгмийн асуудалд ихээхэн анхаарал хандуулдаг.

Бундесверт ахлагч болохын тулд ахлагчийн албанд орох хүсэлт гаргасны дараа ахлагчийн албаны шалгалт өгөх хэрэгтэй. Энэ шалгалт нь 2 өдөр үргэлжилдэг ба оюуны болон спортын чадамжаар нь шалгалт өгөгсдийг сорьж үздэг. Дээрх шалгалтыг давсан бол 12 жил ажиллах гэрээ байгуулж ахлагчийн сургуульд хамрагдаж эхэлнэ. Эхний ээлжид 3 сарын цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл, үүний дараа төрөл мэргэжлээсээ хамаараад аль нэг цэргийн анги дээр төрөлжсөн ерөнхий сургалтад хамрагддаг байна.

ХБНГУ-ын ахлагчийн сургууль нь нэгдүгээрт Удирдлагын анхан шатны сургалт, хоёрдугаарт Ахлагчийн үндсэн дамжааны сургалт, гуравдугаарт Ахлагчийн мэргэжил

дээшлүүлэх сургалт, дөрөвдүгээрт Төрөл мэргэжлийн ахлагчийн сургалтуудыг зохион байгуулдаг байна.

Онц сайн дүнтэй төгссөн ахлагч нар нь мэргэжлийн ахлагч нар нь дараагийн албан тушаал, цол хэргэмд бусад ахлагч нараас түрүүлж дэвших, гадаад дотоодын ЭДА-нд тасгийн захирагчаар үүрэг гүйцэтгэх боломж нь нээлттэй болдог байна. Хэрвээ тэнцээгүй тохиолдолд суралцагч гэрээгээ сунган тухайн албан тушаалдаа ажилладаг.

Санал: ОХУ, БНХАУ, АНУ, ХБНГУ-ын ахлагч бэлтгэх сургалтын ямар туршлагаудыг авч хэрэглэхэд манай улсад тохиромжтой байгаа талаар дараах саналыг дэвшүүлж байна.

ОХУ-ын ахлагч бэлтгэх сургалтын туршлагаас:

Ахлагчийн сургуульд суралцах хугацаа нь тухайн сонсогчийн сонгосон мэргэжлээс шалтгаалж өөр өөр байх.

БНХАУ-ын ахлагч бэлтгэх сургалтын туршлагаас:

Тухайн салбарт шаардлагатай тусгай мэргэжлээр коллежийн төгсөгч, оюутнуудтай гэрээ байгуулан
ЭХ СУРВАЛЖИЙН
ЖАГСААЛТ

1.Тогоо.Ц Цэргийн мэргэжлийн шаталсан сургалтын тогтолцоо, агуулга, арга зүй /докторын диссертаци/. УБ 1998;

2. “Монгол Улсын батлан хамгаалах тухай” Монгол Улсын хууль. Төрийн мэдээлэл, УБ 2016;

3.”Цэргийн албаны тухай” Монгол Улсын хууль. Төрийн мэдээлэл 2016;

4.”Мэргэжлийн боловсрол сургалтын тухай” Монгол Улсын хууль. Төрийн мэдээлэл УБ 2009;

5.”Төрийн өмчийн их сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын

ахлагчаар элсүүлэх, сургалтын төлбөрийг байгууллагаас хариуцдаг байх.

АНУ-ын ахлагч бэлтгэх сургалтын туршлагаас:

Ахлагчийн сургалтууд шаталсан, тасралтгүй, хэлбэрээр явагдах тогтолцоотой ба цол албан тушаал ахихын тулд заавал дараагийн шатны сургалтуудад хамрагддаг.

Ахлагчийн сургалт бүрийн дараа болон шалгалт авсны дараа суралцагчдад ажиглагдсан дутагдалтай талуудыг харилцан ярилцаж, гаргасан алдаа дутагдлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг зааж өгдөг.

ХБНГУ-ын ахлагч бэлтгэх сургалтын туршлагаас:

Ахлагчийн сургуулиа Онц сайн дүнтэй төгссөн ахлагч нар нь дараагийн албан тушаал, цол хэргэмд бусад ахлагч нараас түрүүлж дэвших, гадаад дотоодын ЭДА-нд тасгийн захирагчаар үүрэг гүйцэтгэх боломж нь нээлттэй болдог байна. Хэрвээ тэнцээгүй тохиолдолд суралцагч гэрээгээ сунган тухайн албан тушаалдаа ажилладаг.

байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” МУЗГ-ын 2023 оны 306 дугаар тогтоол;

6.”Ахлагч нарыг бэлтгэх зарим арга хэмжээний тухай” БХЯ УБ 1993;

7.Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын ахлагч нарын боловсрол, мэргэжил, нийгмийн байдал, ахлагчийн албаны шинэчлэл /Захиалгат судалгааны ажлын тайлан/ УБ 2023;

8.Army Regulation 600-8-19: Enlisted Promotions and Reductions:

9.<https://www.ncoworldwide.army.mil/>;

10./Feldwebel-/Unteroffiziere-ohne-portepee;